

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “12. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар” гэж нэмсүгэй.
2. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсгийн “12, 13, 14, 15, 16, 17, 18” дахь дугаарлалтыг “13, 14, 15, 16, 17, 18, 19” гэж өөрчилсүгэй.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Засгийн газар (У.Хүрэлсүх)-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ